



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 75

Арвайхээр

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн нийт мал сүргийн бүтцийг сайжруулах, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор “Үхэр сүрэг” хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, хөтөлбөрийн санхүүжилтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Хөтөлбөрийг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн гурван жилийн хугацаанд хэрэгжүүлсүгэй.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /С.Цэдэнбалжир/-т үүрэг болгосугай.

ДАРГА  А.ИШДОРЖ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 дугаар сарын 24 –ний өдрийн
75 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“ҮХЭР СҮРЭГ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Ерөнхий мэдээлэл

Манай улсын хэмжээнд байгалийн шалгарал болон малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн хөдөлмөр зүтгэл, шинжлэх ухааны үндэслэлтэй сонгон үржүүлгийн ажлын үр дүнд биологийн өвөрмөц онцлог шинж бүхий 49 үүлдэр, омгийн мал байна. Тухайлбал үхрийн Сэлэнгэ үүлдэр, Дорнод талын улаан хэвшил бий болоод байна. Сүү, махны болон мах, сүүний хосолмол Семменталь, Алатау, Хар тарлан, Казакын цагаан толгойт, хар улаан Ангус зэрэг гадаадын өндөр ашиг шимт үхрийг цэврээр болон өөр хооронд нь эрлийзжүүлэн үндсэн сайжруулагчаар ашиглан үржүүлж байна.

Аймгийн 2019 оны эхний мал тооллогын дүнгээр 5.4 сая мал тоологдсоноос үхэр 272.3 мянга байгаа нь нийт мал сүргийн 4.9 хувийг эзэлж байна.

Манай аймгийн хувьд өндөр уулын болон хангайн бүсийн Уянга, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хайрхандулаан, Богд сумдад голлон нийт 100.8 мянган толгой сарлаг үржүүлж байгаа нь нийт үхэр сүргийн 37.0 хувийг эзэлж байна. Сарлаг нь байгаль, цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дан бэлчээрийн маллагаанд гойд зохицон амьдарч, өсөн үржиж чаддаг, 14-16 микрон хөөвөртэй, сүү нь дундажаар 7.0 хувийн тослогтой, махан ашиг шим өндөртэй, онцлог ашиг шим бүхий үхэр сүрэг юм.

Цаашид үхэр сүргийн биологийн нөөц боломжийг бүрэн ашиглах, тархалтын хүрээг өргөтгөх, чанар, үүлдэрлэг байдал, удмын санг хамгаалах, мэдээллийн санг бүрдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн зах зээлд гаргах, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг дэмжиж хамтран ажиллах, малчдын үхэр сүрэг өсгөх сонирхлыг нэмэгдүүлэх, урамшуулахаар “Үхэр сүрэг” дэд хөтөлбөрийг боловсруулж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хөтөлбөрийн зорилго, зорилт

1. Үхэр сүргийн аж ахуй биологийн ашигтай шинж чанарыг үржлийн болон маллагааны цогц арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх, тоо толгойг өсгөх, сүргийн бүтцийг оновчтой болгох, үхэр үржүүлэгчдийн уламжлалт мэдлэг, маллагааны арга барилыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүнд анхан шатны ба эцсийн боловсруулалт хийх, бүтээгдэхүүнийг таниулах, дотоод, гадаад зах зээлд гаргах арга хэмжээ авч, үхрийн халдварт болон халдварт бус, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулах, үхэр сүрэг үржүүлэгчдийг урамшуулахад чиглэсэн бие даасан жил бүрийн төлөвлөсөн төсөв хөрөнгөтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үндсэн зорилт: Үхэр сүргийн үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, инноваци, дэвшилтэт технологитой холбох;

Хоёрдугаар үндсэн зорилт: Зах зээлийн эрэлт хэрэгцээ, технологийн шаардлагад нийцсэн өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх сүлжээ, үйлчилгээ бий болгох;

Гуравдугаар үндсэн зорилт: Үхрийн халдварт болон халдварт бус, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулах;

Дөрөвдүгээр үндсэн зорилт: Үхэр үржүүлэгчдийг дэмжиж, урамшуулах.

3. Хөтөлбөрийн үндсэн зорилтуудын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнг тооцно.

Нэгдүгээр үндсэн зорилтын хүрээнд:

1.1 Нийт үхэр сүргийн генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох, үзлэг, ангилалт, шилэн сонголт, тохируулан сонголт хийж үржлийн цөм сүрэг бүрдүүлэх;

1.2 Үхрийн цөм сүргийг байршил, тархалтын онцлогт тохируулан бий болгох, цөм сүргээс үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах, сайжруулагчаар ашиглах;

1.3 Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар царамын сарлагийн үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшинг тогтоож, цаашид баталгаажсан үүлдэр, омог болгох зорилгоор “Аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох ажлын арга зүй”-г батлуулж ажиллах;

1.4 Жилд 50-аас доошгүй сарлаг үхэрт Бутан, Киркизийн сарлагийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, мах, сүү, ноолуурын ашиг шимийг нэмэгдүүлэх;

1.5 Үржлийн бүртгэл, мэдээллийг хөтөлж, мэдээллийн нэгдсэн санд оруулж, тархалтын хүрээг хянах;

1.6 Үржлийн техникч, ангилагч шинжээчийг бэлтгэх ажлыг зохион байгуулах, үхэр сүргийн үржил, ашиг шимийн онцлогт тохирсон инновацийг нэвтрүүлэх.

Хоёрдугаар үндсэн зорилтын хүрээнд:

2.1 Түүхий эдийг технологийн дагуу бэлтгүүлэн анхан шатны тордолт хийж, ашиг шимийн үнэлэмжийг нэмэгдүүлэн зах зээлтэй холбох;

2.2 Мах, сүү үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, боловсруулах үйлдвэрт бэлтгэн нийлүүлэх боломж бүрдүүлэх.

Гуравдугаар үндсэн зорилтын хүрээнд:

3.1 Үхрийн боом, дуут хавдар, галзуу зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд голомтот бүсийн малыг бүрэн хамруулах;

3.2 Сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээнд тусгайлан заалт оруулж, харьяалах багийн үхэр сүрэгт паразитын эсрэг боловсруулалтыг жил бүр хийх.

Дөрөвдүгээр үндсэн зорилтын хүрээнд:


4.1 Малчид, үхэр үржүүлэгчдийг дэмжиж урд оноос тухайн жилд өссөн тугалын тоогоор урамшуулал олгох;

4.2 Тухайн жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 200-аас дээш үхэр тоолуулсан малчинд “Аймгийн аварга үхэрчин”, үхэр сүргээ 3 жил дараалан өсгөсөн “Аймгийн аварга үхэрчин”-д “Аймгийн хошой аварга үхэрчин” цол тус тус олгож, энгэрийн тэмдэг дурсгалын зүйлээр шагнах;

4.3 Үхэр сүргийн удам угсааг сайжруулан, ашиг шим, тоо толгойг өсгөсөн 2 хүртэлх сум, 5 хүртэлх багийг жил бүр шалгаруулан, сум тус бүрийг 2.0 сая төгрөгөөр, баг тус бүрийг 1.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулах;

4.4 Аймаг орон нутгаас хэрэгжүүлж буй төрөл бүрийн малжуулах төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн 30-аас доошгүй хувьд үхэр сүргээр малжуулах ажлыг зохион байгуулах.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн
 75 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“ҮХЭР СҮРЭГ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Хөтөлбөрийн зорилго				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Үхэр сүргийн аж ахуй биологийн ашигтай шинж чанарыг үржлийн болон маллагааны цогц арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх, тоо толгойг өсгөх, сүргийн бүтцийг оновчтой болгох, үхэр үржүүлэгчдийн уламжлалт мэдлэг, маллагааны арга барилыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүнд анхан шатны ба эцсийн боловсруулалт хийх, бүтээгдэхүүнийг таниулах, дотоод, гадаад зах зээлд гаргах арга хэмжээ авч, үхэр сүрэг үржүүлэгчдийг урамшуулахад чиглэсэн бие даасан жил бүрийн төлөвлөсөн төсөв хөрөнгөтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.				
1. Үйл ажиллагааны чиглэл		Үхрийн генефондыг хамгаалж, тоо толгойг өсгөх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих он
Нэгдүгээр үндсэн зорилт: Үхэр сүргийн үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, инновац, дэвшилтэт технологитой холбох						
1.1	Нийт үхэр сүргийн генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох, үзлэг, ангилалт, шилэн сонголт, тохируулан сонголт хийж үржлийн цөм сүрэг бүрдүүлэх	1.1.1 Үхэр сүрэгт генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох	6700 үхэр	Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид ХХААГ гэх/	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид ХХААХҮЯ гэх/, Сумдын Засаг даргын Тамгын газар /цаашид СЗДТГ гэх/, Мал үржлийн тасаг /МҮТ гэх/	2019
		1.1.2 Аймгийн хэмжээнд үржүүлж буй үхэр сүрэгт үзлэг, ангилалтын ажлыг жил бүр хийх	20.000-аас доошгүй үхэр	ХХААГ	ХХААХҮЯ, СЗДТГ, МҮТ	2019-2022

1.2.1	Үхрийн үзлэг, ангилалтаар тогтоогдсон цөм сүргийн малчдад үржлийн мал бойжуулах эрх олгох	2019-2020	0.25	0.25	0.25								
1.2.2	Стандартын шаардлага хангасан үржлийн бүтээгдэхүүнд /хээлтүүлэгч/ урамшуулал олгох	2010-2021	4.5			2.0	2.0	2.5		2.5			
Зорилт 1.2-ийн Дүн			4.75	0.25	0.25	2.0	2.0	2.5		2.5			
Зорилт 1.3	Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар царамын сарлагийн биологийн онцлог, ашиг шимийн түвшинг тогтоож, цаашид баталгаажсан үүлдэр, омог болгох зорилгоор “Аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох ажлын арга зүй”-г батлуулж ажиллана.												
1.3.1	Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар царамын сарлагийн “Аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох ажлын арга зүй”-г батлуулж ажиллах	2019-2020	10.0			5.0	5.0	5.0		5.0			
1.3.2	Улсын хэмжээнд баталгаажсан сарлагийн омог бий болгох	2019-2020	15.0					5.0		5.0	10.0		10.0
Зорилт 1.3-ийн Дүн			25.0			5.0	5.0	10.0		10.0	10.0		10.0
Зорилт 1.4	Жилд 50-иас доошгүй сарлагт Бутан, Киркизийн сарлагийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, мах, сүү, ноолуурын ашиг шимийг нэмэгдүүлэх												
1.4.2	Гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх	2019-2022	6.0				2.0	2.0	2.0		2.0	2.0	2.0
Зорилт 1.4-ийн Дүн			6.0				2.0	2.0	2.0		2.0	2.0	2.0
Зорилт 1.5	Үржлийн бүртгэл, мэдээллийг хөтөлж, мэдээллийн нэгдсэн санд оруулж сонгон үржүүлэг, тархалтын хүрээг хянах;												


		ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд оруулах				
		1.5.3 Цөм сүргийн үхрийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж мэдээллийн нэгдсэн санд хамруулах	100 хувь	ХХААГ	Сумдын МУТ	2020-2022
1.6	Үржлийн техникч, ангилагч шинжээчийг бэлтгэх ажлыг зохион байгуулах, үхэр сүргийн үржил, ашиг шимийн онцлогт тохирсон инновацийг нэвтрүүлэх	3.1.2 Бод малын техникч, ангилагч шинжээчийг орон нутгаас бэлтгэх	20- хүртэл	ХХААГазар	ХААИС, МУСУТ, СЗДТГ	2020-2021
		3.2.1 МААЭШХ болон ХААИСургуулийн эрдэмтэн багш нарын үхэр сүргийн үржүүлэг, тэжээллэг, арчилгаа маллагааны чиглэлээр хийсэн орчин үеийн бүтээлийг орон нутагт нэвтрүүлэх, нутагшуулах	2-оос доошгүй бүтээл	ХХААГазар	ХААИС, МААЭШХ, СЗДТГ, Төсөл хөтөлбөр	2019-2022
Хоёрдугаар үндсэн зорилт: Зах зээлийн эрэлт хэрэгцээ, технологийн шаардлагад нийцсэн өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх сүлжээ, үйлчилгээ бий болгох						
2.1	Түүхий эдийг технологийн дагуу бэлтгүүлэн анхан шатны тордолт хийж, ашиг шимийн үнэлэмжийг нэмэгдүүлэн зах зээлтэй холбох	2.1.1. Технологийн дагуу түүхий эд бэлтгэх сургалт, сурталчилгаа, мэдээлэл хүргэх	Нийт малчдад	Аймгийн ЗДТГ, ХХААГ, “Ногоон алт төсөл”	СЗДТГ	2019-2022
		2.1.2. Түүхий эдэд анхан шатны тордолт хийж, хамтарч, хоршиж зах зээлд борлуулж хэвших	Хоршоо, малчид	Аймгийн ЗДТГазар, ХХААГазар, “Ногоон алт төсөл”	СЗДТГ	2019-2022
		2.2.2. Чанар, стандартын шаардлага хангасан сарлагийн хөөвөр бэлтгэх сургалт, мэдээллийг малчдад үе шаттайгаар олгох	Жилд 2-оос доошгүй иргэн, аж ахуй нэгж	Аймгийн ЗДТГ, ХХААГ, төсөл, хөтөлбөр	СЗДТГ	2019-2022

3.2.1	Үхрийн гадна, дотор паразитын эсрэг боловсруулалтад нийт үхэр сүргийн 30 хувийг хамруулах	2020-2022	54.0			18.0	18.0	18.0		18.0	18.0	18.0
Зорилт 3.2-ийн Дүн			54.0			18.0	18.0	18.0		18.0	18.0	18.0
Зорилт 3-ийн Дүн			64.8			21.6	21.6	21.6		21.6	21.6	21.6
Дөрөвдүгээр үндсэн зорилт: Үхэр үржүүлэгчдийг дэмжиж, урамшуулах												
Зорилт 4.1		Малчид, үхэр үржүүлэгчдийг дэмжиж урд оноос тухайн жилд өссөн тугалын тоогоор урамшуулал олгох										
4.1.1	Урд оноос тухайн жилд илүү бойжуулсан тугал тутамд урамшуулал олгох	2019-2022	200.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
Зорилт 4.1-ийн Дүн			200.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
Зорилт 4.2		Тухайн жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 200-аас дээш үхэр тоолуулсан малчинд "Аймгийн аварга үхэрчин", үхэр сүргээ 3 жил дараалан өсгөсөн "Аймгийн аварга үхэрчин"-д "Аймгийн хошой аварга үхэрчин" цол тус тус олгож, энгэрийн тэмдэг дурсгалын зүйлээр шагнана.										
4.2.1	Сүүлийн 3 жил дараалан үхэр сүргээ өсгөж 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 200-аас дээш үхэр тоолуулсан малчинд "Аймгийн аварга үхэрчин" цол олгож энгэрийн тэмдэг, дурсгалын зүйлээр шагнах	2019-2021	22.0	10.0	10.0	4.0	4.0	4.0		4.0	4.0	4.0
Зорилт 4.2-ийн Дүн			22.0	10.0	10.0	4.0	4.0	4.0		4.0	4.0	4.0
Зорилт 4.3		Үхэр сүргийн удам угсааг сайжруулан, ашиг шим, тоо толгойг өсгөсөн 2 хүртэлх сум, 5 хүртэлх багийг жил бүр шалгаруулан, сумыг 2 сая төгрөгөөр, баг тус бүрийг 1 сая төгрөгөөр шагнаж урамшуулах										

	гэрээнд тусгайлан заалт оруулж, харьяалах багийн үхэр сүрэгт паразитын эсрэг боловсруулалтыг жил бүр хийх	боловсруулалтад нийт үхэр сүргийн 30 хувийг хамруулах	хамруулах			
Дөрөвдүгээр үндсэн зорилт: Үхэр үржүүлэгчдийг дэмжиж, урамшуулах						
4.1	Малчид, үхэр үржүүлэгчдийг дэмжиж урд оноос тухайн жилд өссөн тугалын тоонд урамшуулал олгох	4.1.1 Урд оноос тухайн жилд илүү бойжуулсан тугал тутамд урамшуулал олгох	1 тугалд 10000 төгрөг	ХХААГ	Аймгийн ЗДТГ, СЗДТГ	2019-2022
4.2	Тухайн жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 200-аас дээш үхэр тоолуулсан малчинд "Аймгийн аварга үхэрчин", үхэр сүргээ 3 жил дараалан өсгөсөн "Аймгийн аварга үхэрчин"-д "Аймгийн хошой аварга үхэрчин" цол тус тус олгож, энгэрийн тэмдэг дурсгалын зүйлээр шагнах	4.2.1 Сүүлийн 3 жил дараалан үхэр сүргээ өсгөж жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 200-аас дээш үхэр тоолуулсан малчинд "Аймгийн аварга үхэрчин" цол олгож энгэрийн тэмдэг, дурсгалын зүйлээр шагнах	Болзол хангасан малчны тоогоор	ХХААГ	Аймгийн ЗДТГ, СЗДТГ	2019-2022
		4.2.1 "Аймгийн аварга үхэрчин" цол авснаас хойш 3 жил дараалан үхэр сүргээ өсгөсөн малчныг "Аймгийн хошой аварга үхэрчин" цол олгож энгэрийн тэмдэг, дурсгалын зүйлээр шагнах	Болзол хангасан малчны тоогоор	ХХААГ	Аймгийн ЗДТГ, СЗДТГ	2019-2022
4.3	Үхэр сүргийн удам угсааг сайжруулан, ашиг шим, тоо толгойг өсгөсөн сум-2, баг-5-ийг жил бүр шалгаруулан, сумыг 2 сая төгрөгөөр, баг тус бүрийг 1 сая төгрөгөөр	4.3.1 Үхэр сүргийн тоо толгойг өсгөсөн сум, баг, малчныг жил бүр шалгаруулж урамшуулах	1 сум, 5 баг	ХХААГ	Аймгийн ЗДТГ, СЗДТГ	2019-2022

	шагнаж урамшуулна					
4.4	Аймгийн өвс тэжээлийн нөөцийн 50 хувийг "Үхэр сүргийг ган зудаас хамгаалах" нөөцөд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	4.4.1 Үхэр сүргийг ган зудаас хамгаалах бодлого хэрэгжүүлж ажиллах	Жилд 100 тн тэжээл, 50 тонн өвс нөөцөөс үхэр сүрэгт зарцуулагдана.	ХХААГ	СЗДТГ, малчид	2019-2022

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн
75 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



“ҮХЭР СҮРЭГ ӨСГӨХ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО

/сая төгрөгөөр/

№	Хөтөлбөрийн зорилго, зорилт	Эхлэх, дуусах огноо	Нийт	2019 он			2020 он			2021 он			2022				
				Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт		
Нэгдүгээр үндсэн зорилт: Үхэр сүргийн үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, инноваци, дэвшилтэт технологитой холбох																	
Зорилт 1.1		Нийт үхэр сүргийн удам зүйн төлөв байдлыг тогтоох, үржлийн цөм сүрэг бүрдүүлэх															
1.1.1	Үхэр сүрэгт генетик нөөцийн төлөв байдлыг тогтоох	2019	4.1	4.1	4.1												
1.1.2	Аймгийн хэмжээнд үржүүлж буй үхэр сүрэгт үзлэг, ангилалтын ажлыг жил бүр хийх	2019-2022	16.0	4.0	4.0	4.0		4.0	4.0		4.0	4.0		4.0	4.0		
Зорилт 1.1-ийн Дүн			20.1	8.1	8.1	4.0		4.0	4.0		4.0	4.0		4.0	4.0		
Зорилт 1.2	Үхрийн цөм сүргийг байршил, тархалтын онцлогт тохируулан бий болгох, цөм сүргээс үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах, сайжруулагчаар ашиглах																

1.2	Үхрийн цөм сүргийг байршил, тархалтын онцлогт тохируулан бий болгох, цөм сүргээс үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах, сайжруулагчаар ашиглах	1.2.1 Үхрийн үзлэг, ангилалтаар тогтоогдсон цөм сүргийн малчдад үржлийн мал бойжуулах эрх олгох	30 хүртэлх малчин	ХХААГ	ХХААХҮЯ, СЗДТГ, МҮТ, малчид	2019-2022
		1.2.2 Стандартын шаардлага хангасан үржлийн бүтээгдэхүүнд /хээлтүүлэгч/ урамшуулал олгох	1 буханд 20.000 төгрөг	ХХААГ	СЗДТГ, МҮТ, малчид	2020-2021
1.3	Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар царамын сарлагын биологийн онцлог, ашиг шимийн түвшинг тогтоож, цаашид баталгаажсан үүлдэр, омог болгох зорилгоор “Аж ахуй, биологийн онцлог, ашиг шгимийн түвшин тогтоох ажлын арга зүй”-г батлуулж ажиллах	1.3.1 Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар царамын сарлагын “Аж ахуй, биологийн онцлог, ашиг шгимийн түвшин тогтоох ажлын арга зүй”-г батлуулж ажиллах	2020 онд 1 арга зүй батлуулсан байна.	ХХААГ	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн /цаашид МААЭШХ гэх/, Уянга сумын ЗДТГазар, МҮТ,	2020-2022
		1.3.2 Улсын хэмжээнд баталгаажсан сарлагийн омог бий болгох	Баталгаажсан 2 дахь омгийн малтай болно.	ХХААГ, Уянга сумын ЗДТГ, МҮТ,	ХХААХҮЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /цаашид МХЕГ гэх/	2021-2022
1.4	Жилд 50-иас доошгүй сарлагт Бутан, Киркизийн сарлагийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, мах, сүү, ноолуурын ашиг шимийг нэмэгдүүлэх	1.4.1 Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран үр импортлох ажлыг зохион байгуулах	300-аас доошгүй тун үр оруулж ирсэн байна.	ХХААГ	ХХААХҮЯ, МУСҮТ, ХХААГ	2020-2022
		1.4.2 Гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх	150-иас доошгүй үнээ	ХХААГ	МУСҮТ, МААЭШХ, СЗДТГ, МҮТ, малчид	2020-2022
1.5	Үржлийн бүртгэл, мэдээллийг хөтөлж, мэдээллийн нэгдсэн санд оруулж, тархалтын хүрээг хянах	1.5.1 Үржилд ашиглагдаж буй нийт үхэр сүргийн хээлтүүлэгчийг эзэмгжүүлэн, бүртгэлжүүлж мэдээллийн нэгдсэн санд оруулах.	Хээлтүүлэгч 100 хувь	ХХААГ	Сумдын МҮТ	2020-2022
		1.5.2 Зохиомол хээлтүүлэгт орсон хээлтэгч, гарсан төлийг	100 хувь	ХХААГ	Сумдын МҮТ	2020-2022

1.5.1	Үржилд ашиглагдаж буй нийт үхэр сүргийн хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн, бүртгэлжүүлж мэдээллийн нэгдсэн оруулах	2019-2022	0.6			0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	
1.5.2	Зохиомол хээлтүүлэгт орсон хээлтэгч, гарсан төлийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд оруулах	2019-2022	0.6			0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	
1.5.3	Цөм сүргийн үхрийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж мэдээллийн нэгдсэн санд хамруулах	2019-2022	4.5			1.5	1.5	1.5	1.5	1.5	1.5	
Зорилт 1.5-ийн Дүн			5.7			1.9	1.9	1.9	1.9	1.9	1.9	
Зорилт 1-ийн дүн			61.55	8.35	8.35	14.9	14.9	20.4	20.4	17.9	17.9	
Гуравдугаар үндсэн зорилт: Үхрийн халдварт болон халдварт бус, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулах												
Зорилт 3.1		Үхрийн боом, дуут хавдар, галзуу зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд голомтот бүсийн малыг бүрэн хамруулах										
3.1.1	Дуутын вакцинд голомтот бүсийн малыг бүрэн хамруулах	2020-2022	10.8			3.6	3.6	3.6	3.6	3.6	3.6	
Зорилт 3.1-ийн Дүн			10.8			3.6	3.6	3.6	3.6	3.6	3.6	
3.2	Сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээнд тусгайлан заалт оруулж, харьяалах багийн үхэр сүрэгт паразитын эсрэг боловсруулалтыг жил бүр хийх											

2.2	Мах, сүү үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, боловсруулах үйлдвэрт бэлтгэн нийлүүлэх боломж бүрдүүлэх	2.2.1 Малчдыг чадавхижуулах сургалтуудыг шат дараатай зохион байгуулж, стандартын шаардлагад нийцсэн түүхий эд бэлтгэн нийлүүлэхэд сургаж, дадлагажуулах замаар мах, сүүг эргэлтэд оруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийг сайжруулах	Жилд 5-аас доошгүй сургалт, сурталчилгаа, мэдээлэл хийгдэж, ХАА-с үйлдвэрлэсэн мах, сүүний хэмжээ урд оноос өссөн байна.	ХХААГ, Мал эмнэлгийн газар /цаашид МЭГ гэх/	СЗДТГ	2019-2022
		2.2.2 Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих арга хэмжээг олон улсын хөрөнгө оруулагчид, төсөл хөтөлбөрийн байгууллага болон хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан хамтран хэрэгжүүлэх	Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХОХБХ гэх/, ХХААГ, СЗДТГ	Олон улсын хөрөнгө оруулагчид, Төсөл хөтөлбөрийн байгууллага, хувийн хэвшил	2019-2022
Гуравдугаар үндсэн зорилт: Үхрийн халдварт болон халдварт бус, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулах						
3.1	Үхрийн боом, дуут хавдар, галзуу зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд голомтот бүсийн малыг бүрэн хамруулах	3.1.1 Дуутын вакцинд голомтод бүсийн малыг бүрэн хамруулах	Жилд 36000 үхэр сүргийг хамруулсан байна.	ХХААГ, МЭГ	СЗДТГ, Мал эмнэлгийн тасаг /цаашид МЭТ гэх/, МЭҮНэгж	2020-2021
3.2	Сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн	3.2.1 Үхрийн гадна, дотор паразитын эсрэг	Жилд 30000 үхэр сүргийг	ХХААГ, МЭГ	СЗДТГ, МЭТ, МЭҮНэгж	2020-2021

4.3.1	Үхэр сүргийн тоо толгойг өсгөсөн сум, баг, малчныг жил бүр шалгаруулж урамшуулах	2019-2022	36.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
Зорилт 4.3-ийн Дүн			36.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
Зорилт 4-ийн дүн			258.0	69.0	69.0	63.0	63.0	63.0	63.0	63.0	63.0	63.0
Хөтөлбөрийн Дүн		2019-2022	384.35	77.35	77.35	99.5	99.5	105.0	105.0	102.5	102.5	102.5
Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ		2019-2022	384.35	77.35	77.35	99.5	99.5	105.0	105.0	102.5	102.5	102.5
Санхүүжилтийн эх үүсвэр		2019-2022										
Улсын төсөв		20.1	20.1	8.1	8.1	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0
Орон нутгийн төсөв		364.25	364.25	69.25	69.25	95.5	95.5	101.0	101.0	98.5	98.5	98.5
Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламж												